



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/37

Хэрлэн сум

Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60.1.10, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 заалтуудыг үндэслэн авто тээврийн хэрэгслийн татвар хураалтыг 2025 оны 06 дугаар сарын 01-ний дотор, Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг үндэслэн техникийн хяналтын үзлэгийг жилийн туршид зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Авто тээврийн төвийн дарга
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Аймгийн Татварын газрын дарга
	Хэнтий аймгийн Цагдаагийн газрын дарга

3. Сумдад авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах хуваарийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Өөрийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн албан татварыг зохих журмын дагуу төвлөрүүлэн, авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

5. Батлагдсан хуваарийн дагуу авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгсэл, улсын дугаар аваагүй мотоциклийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглон, зөрчлийг арилгуулахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Э.Жавхлантөгс)-д, техникийн

2.

хяналтын үзлэгээс хоцорсон тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт тухай бүрд нөхөн оруулах, гаалийн бичигтэй мотоцикльд улсын дугаар олгож, тээврийн хэрэгслийн VRS системд бүртгэхийг Авто тээврийн төвийн дарга (Ц.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

6.Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг хагас бүтэн жилээр дүгнэн, дүнг танилцуулахыг комиссын даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2025 оны
 дүгээр сарын 29-ний өдрийн
 А/34 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН АВТО ТЭЭВРИЙН ОРОН НУТАГТ ТЕХНИКИЙН
 ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙГ ЯВУУЛАХ ХУВААРЬ

№	Сумдууд	Явах хоног	сар өдөр	Ажлын бүрэлдэхүүн
1.	Өлзийт	1	2025 оны 04 сарын 01	Техникийн хяналтын үзлэгийн инженер Б.Баярмагнай Техникийн хяналтын үзлэгийн инженер С.Наранхүү Бүртгэлийн мэргэжилтэн Г.Эрийнтовч Авто тээврийн хяналтын улсын байцаагч Ч.Лэгдэнболд Тээвэр зохицуулагч Г.Сарантуяа
	Мөрөн	2	2025 оны 04 сарын 02-оос 2025 оны 04 сарын 03	
	Баянхутаг	2	2025 оны 04 сарын 04-өөс 2025 оны 04 сарын 05	
	Галшар	3	2025 оны 04 сарын 08-аас 2025 оны 04 сарын 10	
	Бор-Өндөр	8	2025 оны 04 сарын 11-ээс 2025 оны 04 сарын 18	
	Бор-Өндөр УБҮ, Баргилтын уурхай, Бусад уурхай	3	2025 оны 04 сарын 19-өөс 2025 оны 04 сарын 21	
	Дархан	3	2025 оны 04 сарын 22-оос 2025 оны 04 сарын 24	
	Баянмөнх	4	2025 оны 04 сарын 25-аас 2025 оны 04 сарын 28	
	ХБУлаан	1	2025 оны 04 сарын 29	
	Дэлгэрхаан	3	2025 оны 04 сарын 30-аас 2025 оны 05 сарын 02	
	Цэнхэрмандал	4	2025 оны 05 сарын 03-аас 2025 оны 05 сарын 06	
	Өмнөдэлгэр	8	2025 оны 05 сарын 07-оос 2025 оны 05 сарын 14	
	Жаргалтхаан	5	2025 оны 05 сарын 15-аас 2025 оны 05 сарын 19	
	Хурх	1	2025 оны 05 сарын 20	
Батширээт	3	2025 оны 05 сарын 21-ээс 2025 оны 05 сарын 23		
Биндэр	5	2025 оны 05 сарын 24-өөс 2025 оны 05 сарын 28		
2.	Баян адрага	3	2025 оны 05 сарын 29-өөс 2025 оны 05 сарын 31	
3.	Дадал	3	2025 оны 06 сарын 02-оос 2025 оны 06 сарын 04	
	Норовлин	3	2025 оны 06 сарын 05-аас 2025 оны 06 сарын 07	
	Баяновоо	3	2025 оны 06 сарын 08-аас 2025 оны 06 сарын 10	

Батноров	5	2025 оны 06 сарын 11-ээс 2025 оны 06 сарын 15
Бэрх	3	2025 оны 06 сарын 16-аас 2025 оны 06 сарын 18
Тахилгат	1	2025 оны 06 сарын 19
Орон нутагт	77	

Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 29-ний өдрийн
A/137 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Хэнтий аймгийн авто тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн хяналтын үзлэг явуулах ажлын удирдамж

Нэг. Зорилго:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.2 дахь хэсгийг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Хугацаа

Авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг явуулах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл

Гурав. Хэрэгжүүлэгч байгууллага:

- Хэнтий аймгийн Авто тээврийн төв Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд
- Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар
- Хэнтий аймгийн Цагдаагийн газар
- Хэнтий аймгийн Татварын хэлтэс
- Сумдын Засаг даргын Тамгын газар

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Ажлын алба	Хийх ажлын хуваарь	Хариуцах эзэн
1	Хэнтий аймгийн Авто тээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн инженер Б.Баярмагнай С.Наранхүү	1.Аж ахуйн нэгж, албан байгууллагуудыг ажлын ачаалал, тээврийн хэрэгслийн тоог харгалзан хуваарь гарган 2025 онд бүрэн хамруулах; 2.Ажлын хэсгийн ахлагч нь сумдын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, ажлыг дүгнэн татвар төлөлт, үзлэгт хамрагдсан байдал, сумын комиссын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, тэмдэглэл хөтөлнө; 3.Тээврийн хэрэгсэл бүрд бүртгэл хөтлөн суурин, явуулын тоног төхөөрөмжөөр техникийн хяналтын үзлэгийг гүйцэтгэж, тэнцсэн тохиолдолд тээврийн хэрэгслийн гэрчилгээнд тэмдэглэл хийнэ.Тэнцээгүй тээврийн хэрэгслийг засвар үйлчилгээ хийгдсэний дараа үнэ төлбөргүй ахин нэг удаа үзлэгт хамруулна.	Авто тээврийн төвийн дарга Ц.Бат-Эрдэнэ

2	Хэнтий аймгийн Авто тээврийн төвийн бүртгэлийн мэргэжилтэн Г.Эрийнтовч	<p>1. Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, улсын дугаар олголт, гаалийн бичигтэй шинэ тээврийн хэрэгслийг бүртгэх, тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах;</p> <p>2. Сумдын тээврийн хэрэгслийн судалгаа гаргаж дахин ашиглагдах боломжгүй тээврийн хэрэгслийн эзэмшигчээс хүсэлт авч хасалт хийх;</p>	Авто тээврийн төвийн дарга Ц.Бат-Эрдэнэ
3	Хэнтий аймгийн Авто тээврийн төвийн хяналтын мэргэжилтэн Ч.Лэгдэнболд	<p>1. Захирамжийн хүрээнд ажиллаж буй албан хааг нарт холбогдох дүрэм журам, стандартын дагуу үйлчилгээ үзүүлж буйд хяналт тавих;</p> <p>2. Сумдад авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн судалгааг гаргах, ангиллын гэрчилгээ олгох, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөх;</p>	Авто тээврийн төвийн дарга Ц.Бат-Эрдэнэ
4	Хэнтий аймгийн Авто тээврийн төвийн тээвэр зохицуулагч Г.Сарантуяа	1. Тээврийн хэрэгслийн ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭ-г (RFID tag) сумдын тээврийн хэрэгсэлд нааж бүртгэлд хамруулна, байгууллагын үйл ажиллагаау нэвтэрч буй цахим үйлчилгээнүүдийг иргэдэд сурталчлан таниулах,	Авто тээврийн төвийн дарга Ц.Бат-Эрдэнэ
5	Аймгийн татварын хэлтэс, Сумын ЗДТГ	<p>1. Сумын засаг даргын захирамжаар комисс томилж бэлтгэл ажлыг хангана.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын комисст татварын байцаагч, багийн Засаг дарга нар, цагдаагийн ажилтан, үүрэг бүхий бусад хүмүүсийг оролцуулна. • Татвар хураалтыг урьдчилан зохион байгуулсан байна. Хуваарьт өдөр комисс ажиллах нөхцөлийг бүрдүүлж, үзлэг явуулах байр талбайн бэлтгэлийг хангана. • Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг баг, байр, хэсгүүдээр нь хуваарь гаргаж үзлэгт, хамрагдах өдрийг урьдчилан зарлаж гарын үсгээр баталгаажуулсан байна. <p>2.Сумд дахь татварын байцаагч нь багийн Засаг дарга нарын бүртгэлийг сумын хэмжээний нийт тээврийн хэрэгслийн нэгдсэн бүртгэлтэй тулган татвар төлөлтөд хяналт тавьж, үзлэгт орсон тээврийн хэрэгслийн тоотой тулгалт хийн татварын орлогын дүнг нэгтгэн гаргаж комисст илтгэнэ.</p>	Татварын хэлтсийн дарга А.Гантөмөр Сумын Засаг дарга
6	Аймгийн цагдаагийн газар, Сумд дахь Цагдаагийн тасгийн дарга, Байцаагч, төлөөлөгч нар	<p>1.Сумын цагдаагийн тасаг, хэсгийн төлөөлөгч техникийн үзлэг, явагдах хуваарьт өдрүүдэд, комиссын бүрэлдэхүүнд ажиллан хөдөлгөөн зохицуулах, зогсоол талбайд байрлуулах, дэг журам сахиулах ажлыг гүйцэтгэнэ.</p> <p>2.Комиссын бүрэлдэхүүн ажиллах өдрүүдэд үзлэгт хамрагдаж байгаа</p>	Аймгийн Цагдаагийн Газрын дарга Э.Жавхлантөгс

	<p>тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт туслах ,комиссын ажлыг дэмжиж ажиллах</p> <p>3.Хуваарьт хугацаанд үзлэгт ороогүй буюу урьд жилийн хугацаа хэтэрсэн тээврийн хэрэгсэл эзэмшигчид хариуцлага тооцох, ТХГ-ээг АТҮТөвд шилжүүлэх замаар үзлэгт хамруулах ажлыг жилийн турш зохион байгуулан хэрэгжүүлж мэдээлж байх.</p> <p>4.Улсын дугааргүй гаалийн бичигтэй мотоциклийн эзэмшигч нарын судалгаа гаргаж улсын дугаар авахыг шаардаж хяналт тавьж ажиллах.</p>	
--	--	--